

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ АРВАН НАЙМДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны тавдугаар сарын 21-ний 14 цаг 05 минутад эхэлж, 15 цаг 42 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 37 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 1. Мөнхөөгийн Батбаяр, Наваантаяын Бат-Эрдэнэ нарыг Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх 2. Нөөцөд бүртгэгдсэн иргэдээс Мөнхөөгийн Батбаярыг Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Эрдэнэбүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Шүүхийн ерөнхий зөвлөлийн зарим удирдах албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн

	<p>дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"> - Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалд - Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн Ёс зүйн хорооны ажлын албаны даргын албан тушаалд 	<p>жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Гурдагвын Цэвээндоржийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Намдагийн Ганбаатарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн ёс зүйн хорооны Ажлын албаны даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндоржид санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Аж үйлдвэрийн яамны зарим удирдах албан тушаалд томилогдох ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилогдох 	<p>Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 03/1514 тоот албан бичгээр Аж үйлдвэрийн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын, Хөнгөн үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын даргын,</p>

	<ul style="list-style-type: none"> - Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилогдох - Жижиг, дунд үйлвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох - Хөнгөн үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилогдох 	<p>Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга ирүүлснийг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн csc.gov.mn сайтаар нийтэд нээлттэй зарлаж, зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
4	<p>Говьсүмбэр, Дорнод, Увс аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 05 дугаар сарын 01-08-ны өдрүүдэд Говьсүмбэр аймаг, Дорнод аймаг, Увс аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Говьсүмбэр аймаг, Дорнод аймаг, Увс аймагт 2015 оны 05 дугаар сарын 01-08-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2, 3 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 34 иргэн /Говьсүмбэр аймагт 12, Дорнод аймагт 14, Увс аймагт 8/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 4, 5, 6 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 13 иргэн /Говьсүмбэр аймагт 4, Дорнод аймагт 4, Увс аймагт 5/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх</p>

		<p>хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 7, 8, 9 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 14 иргэн /Говьсүмбэр аймагт 7, Дорнод аймагт 3, Увс аймагт 4/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 10, 11, 12 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 8 иргэн /Говьсүмбэр аймагт 2, Дорнод аймагт 1, Увс аймагт 5/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх</p> <p>3. Энэхүү тогтоолын 7-12 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 22 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөл /Б.Батдэлгэр/-д, Төрийн албаны зөвлөлийн Дорнод аймаг дахь салбар зөвлөл /П.Бат-Өлзий/-д, Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөл /Г.Болор-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	Төрийн албаны зөвлөлийн Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нэр, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар

		<p>тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2, 1.4, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг"-ийг баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын "нэг"-ийн 11-д "Төрийн албаны зөвлөлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн" гэснийг "Төрийн албаны зөвлөлийн Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн" гэж өөрчилж, бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн батлах.</p> <ol style="list-style-type: none">1. Төрийн нарийн бичгийн дарга;2. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газрын дарга;3. Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;4. Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;5. Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;6. Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;7. Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;8. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга;9. Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөц, шагналын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн <p>тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

6	<p>Төрийн албаны зөвлөлийн зарим Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай</p> <ul style="list-style-type: none"> - Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах - Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах 	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, 1.4, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”-ийг баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын “Хоёр”-ын 8-д “Төрийн албаны зөвлөлийн Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн” гэсэн хэсгийг дараах байдлаар өөрчлөх.</p> <ol style="list-style-type: none"> 1. Ерөнхий газрын дарга; 2. Дэд дарга; 3. Захиргаа, удирдлагын газрын дарга; 4. Шалган нэвтрүүлэх газрын дарга; 5. Хяналт, шалгалтын газрын дарга; 6. Дотоод хяналт, дүн шинжилгээ, аудитын газрын дарга; 7. Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга; 8. Хүний нөөцийн хэлтсийн дарга; 9. Хүний нөөцийн хэлтсийн мэргэжилтэн <p>тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар</p>
---	--	---

		<p>тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2, 1.4, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг"-ийг баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар өөрчлөх Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны Шүүхийн хүний нөөцийн газрын дарга - Шүүхийн захиргааны удирдлагын газрын дарга - Шүүхийн санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, - Шүүхийн хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга - Шүүхийн захиргааны хэлтсийн дарга - Дотоод аудитын албаны дарга - Хүний нөөц хариуцсан ахлах референт <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулж Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар тогтоолын 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
7	Зарим хүмүүсийг "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах тухай	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх</p>

		<p>санаачлагатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан дараах нэр бүхий 41 төрийн албан хаагчдыг Монгол Улсын “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнах</p> <p>2. Шагнагдсан хүн тус бүрийн тэмдгийг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам”-ын 4.2-т заасны дагуу шагнагдагсдад тухайн байгууллагаас олгох</p> <p>3. Шагнагдсан нийт төрийн албан хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүсэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	---